



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4, дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Стандарт хэмжил зүйн газрын харьяа Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн, засаж сэлбэн ашиглах боломжгүй 4 нэрийн нийт 57,990,000.00 (тавин долоон сая есөн зуун ерэн мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Стандарт хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн, Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга С.Чулуунбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001335

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн  
03 дугаар тогтоолын хавсралт

**ОРХОН АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ  
АКТАЛЖ ДАНСААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Ачаат бүлүүрт манометр (fluke p3014-мар)	ш	1	2014.12.15	33,945,000.00	33,945,000.00
2	Даралтын аппарат шалгах симулятор	ш	1	2014.12.15	20,965,000.00	20,965,000.00
3	Дэлгэц самбар	ш	1	2011.05.23	1,980,000.00	1,980,000.00
4	Архивын шүүгээ	ш	2	2012.06.26	550,000.00	1,100,000.00
<b>Нийт дүн</b>						<b>57,990,000.00</b> (Тавин долоон сая есөн зуун ерэн мянга )